



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Европын Холбоо  
хамтран санхүүжүүлэв



Хэрэгжүүлэгч байгууллага

**giz** Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH



Food and Agriculture  
Organization of the  
United Nations

# STREAM ЦАХИМ ТОВХИМОЛ

ДУГААР #2: 2023 ОНЫ 1-9 САР

## Онцлох мэдээ

### ХӨДӨӨ АЖ АХУЙ БА ОЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

- ✓ Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө
- ✓ Агроэкологийн өртгийн сүлжээ
- ✓ Тэжээл үйлдвэрлэл
- ✓ Агро-ойн туршилтын загвар
- ✓ Чадавх бэхжүүлэх сургалт (ХАА)
- ✓ Ойн тогтвортой менежмент (ОТМ)-ийн туршилт судалгаа
- ✓ Чадавх бэхжүүлэх сургалт (ОТМ)
- ✓ Мод үржүүлгийн газар
- ✓ “Ойн судалгаа, бодлогын шинэчлэл” олон улсын зөвлөгөөн
- ✓ Олон улсын туршлага судлах аялал
- ✓ Хүүхэд, залууст ОТМ-ийн мэдлэг олгох нөлөөллийн арга хэмжээ

“ХӨДӨӨ АЖ АХУЙН МЕНЕЖМЕНТ,  
ЭКОСИСТЕМИЙН ТОГТВОРТОЙ  
БАЙДЛЫГ ХАНГАХ (STREAM)” ТӨСӨЛ



## СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил амжилттай үргэлжилж, иргэдийн оролцоог хангах, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор цуврал хэлэлцүүлгүүд зохион байгуулж санал авахад онцгойлон анхаарч ажиллалаа. Сэлэнгэ аймгийн Ерөө, Жавхлант, Мандал болон Хэнтий аймгийн Биндэр суманд зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт сумдын удирдлагууд болон ХАА, газар, байгаль орчны мэргэжилтнүүд, малчид, фермерүүд, орон нутгийн ТББ, хоршоодын төлөөлөл 1800 гаруй хүн оролцлоо. Иргэдийн саналыг тусган сайжруулснаар сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө тус сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдлаа. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө нь сумын нийт нутгийг хамарсан газар зохион байгуулалт, газрын нөөцийн менежментийн 5-7 жилийн баримжаатай дунд хугацааны төлөвлөгөөний чухал баримт бичиг юм. [Цааш унших](#)

## ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ



## АГРОЭКОЛОГИЙН ӨРТГИЙН СҮЛЖЭЭ



Махны нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх замаар малын тоо толгойг бууруулах зорилгын хүрээнд Монгол үхэр болон хонины үүлдрийг сайжруулж, биеийн жинг түргэн өсгөж, махны гарц, чанарыг дээшлүүлэн, зах зээлд эрт борлуулах зорилгоор Улаан Ангусын гүн хөлдөөсөн үрээр 90 өрхийн 1150 үнээнд, Алтай үүлдрээр 9 өрхийн 558 хонинд зохиомол хээлтүүлэг хийж, хээл авалтын дундаж хувь 77 байлаа. Ингэснээр шинэ төлийн өсөх болон бордоо авах чадварыг орон нутагт таниулан, харуулахаар зорьж байна. [Цааш унших](#)

Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдад зориулсан “Малын зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх” сургалтад төслийн зорилтот сумдаас 8 хүн хамрагдаж, техникчээр бэлтгэгдсэн бөгөөд тэд сурсан мэдсэнээ практикт хэрэгжүүлж, малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

Энэхүү ажлыг зохион байгуулснаар малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр орон нутагт чадавч бий болоход хувь нэмэр оруулж байна. Монгол малын үүлдэр угсааг сайжруулах ажлыг хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцүүлэн хэрэгжүүлж байна. [Цааш унших](#)



Мөн төөнөх аргаар мал хөнгөлөх сургалтыг төсөл хэрэгжиж буй сумдын холбогдох мал аж ахуйн мэргэжилтэн, малчдыг хамруулан зохион байгууллаа. Малыг эдийн засгийн эргэлтэд эрт оруулах, өсвөр малын өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор 50 орчим өсвөр үхэр, 480 хургыг төөнөх аргаар хөнгөлөх ажлыг хийж гүйцэтгэлээ. [Цааш унших](#)

# ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ



Төөнөх аргаар хурга хөнгөлж буй байдал

## ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛ

Үхэр, хонины махны өртгийн сүлжээг хөгжүүлэх, орон нутагт малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлж, өсвөр мал бордох уураг, эрдэст тэжээлийн нөөц бий болгох зорилгоор цагт 900-1000 кг тэжээл үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг орон нутгийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж Хангай ХХК-тай хамтран байгууллаа. Хангай компани нь Хэнтий аймаг төдийгүй зүүн бүс нутагт тэжээлийн хэрэгцээг хангахуйц өндөр хүчин чадал бүхий үйлдвэр юм.

Бүрэн найрлагат багсармал тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх төрлийн малд шаардлагатай 9 төрлийн тэжээлийн жор боловсруулахад төслөөс дэмжлэг үзүүлж, үйлдвэрлэх зөвлөмж өглөө. Мөн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр Хангай компанийн боловсон хүчний чадавхыг сайжруулахад ихээхэн хувь нэмэр орууллаа.

## ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ



Энэ ажлын үр дүнд Хангай компани 2 төрлийн 20 гаруй тонн тэжээл үйлдвэрлэж, малчид, хэрэглэгчдэд үйлдвэрийн үнээр борлуулсан бөгөөд өнгөрсөн өвөл төслийн зорилтот сумдад цаг хүндрэлтэй байсан ч ядарсан малд чухал шаардлагатай тэжээл болсныг малчид дурдлаа. [Цааш унших](#)

## АГРО-ОЙН ТУРШИЛТЫН ЗАГВАР

Төслийн дэмжлэгээр агро-ойн туршилтын загвар байгуулах ажлыг Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын 2 талбай болон Ерөө сумын мод тарих сургалтын талбайд эхлүүлэв. [Цааш унших.](#)

Загвар талбай байгуулах ажлыг зардал хуваах зарчмаар, төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэл хэлбэрээр зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнүүдийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ Дунджаар 90 хувийн амьдралтай 8,600 орчим мод тарьж, ургуулах,
- ✓ Модны усалгааг бүрэн шийдвэрлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг гаргах,
- ✓ Худгийн эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилго бүхий 380м урттай агаарын цахилгаан шугам татах,
- ✓ Усалгааны үр ашгийг сайжруулах, ус хэмнэх, хөрс хамгаалах дэвшилтэт арга барилуудыг нэвтрүүлэх зорилгоор, 25 м<sup>3</sup>-ийн багтаамжтай усан сан бүхий дуслын усалгааны систем суурилуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.
- ✓ Эдгээр талбайг түшиглэн орон нутгийн иргэдэд мод, бут, хүнсний ногоо тариалах, арчлах, хортны хяналт зэрэг олон чиглэлээр технологийн сургалтуудыг зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Жавхлант суманд Шарын гол ногоочдын бүлгийн агро-ойн талбайд нарны эрчим хүчээр ажилладаг цахилгаан хашаа суурилуулж мал бэлчээрлэлтийн нөлөөнөөс хамгаалсан. Элсний нүүдэлд өртсөн талбайг хашиж хамгаалан байгалийн аясаар сэргэн ургах процессыг дэмжих тус арга хэмжээний үр дүнд га-ийн ургац 2.5 т/га-д хүрсэн нь ижил төстэй соргог бэлчээрийн дундаж ургацын хэмжээнд хүрсэн үзүүлэлт боллоо. Тус талбай нь нутгийн иргэд, малчдад ногоон эрчим хүч ашиглан доройтсон бэлчээрийг хэрхэн нөхөн сэргээх арга замыг бодитой, загвар байдлаар харуулсан ба нийт 300 гаруй малчид газар дээр нь биечлэн танилцаж, туршлага судаллаа.




Агро-ойн загвар талбай: цахилгаан хашаа барихын өмнөх ба дараах байдал

## ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ

Төслийн зорилтот 6 сумын малчид, фермерүүд, зөгийчид зэрэг 550 гаруй хүнд хүнсний ногоо, мөн мод бутыг үрээр болон мөчрөөр тариалах, арчлах, ургамал хамгаалал, зөгий үржүүлэг, хоршоо хөгжүүлэх чиглэлээр онолын болон практик сургалт зохион байгуулж, мэдлэг, ур чадварыг нь сайжрууллаа. Сургалтад оролцогчдын 53 орчим хувь нь эмэгтэйчүүд байлаа. [Цааш унших](#)

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ногоочин Ш.Оюунчимэг төслөөс зохион байгуулсан цуврал сургалтаар буурцагт ургамал тариалахад суралцаж, энэ жил анх удаа вандуй, шошийг өөрийн талбайд тариалжээ. Эдгээр онол, дадлага хосолсон сургалт нь оролцогчдод шаардлагатай бодит ур чадвар олгох болон бие биеэсээ суралцах боломж олгож байгаа талаар тэрээр сэтгэгдлээ хуваалцлаа. [Цааш унших](#)

■ Эрэгтэй ■ Эмэгтэй



Оролцогчдын тоо, хүйсээр



# ОЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

## ОЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН ТУРШИЛТ, СУДАЛГАА



Жавхлант сум дахь туршилтын талбай  
(хашаалсны дараа):  
2022 оны 8-р сарын 21



Жавхлант сум дахь туршилтын талбай:  
2023 оны 8-р сарын 24

Сэлэнгэ, Хэнтий аймгийн зургаан сумдад байгуулсан ойн тогтвортой менежмент (ОТМ)-ийн туршилт, судалгааны талбай нь ойн аж ахуйн зарим арга хэмжээг загвар байдлаар хэрэгжүүлж, олонд таниулах зорилготой юм. Энэхүү арга хэмжээнүүд нь ойн эрүүл мэнд, тогтвортой байдлыг сайжруулахын зэрэгцээ ойн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Үүнээс гадна мод, бут, сөөгний тооллого, ургамалан бүрхэвчийн үнэлгээ, шавжийн тооллого, хөрсний төлөв байдлын судалгаа, задралын түвшин, мөнх цэвдгийн гүнийг тодорхойлох зэрэг ажиглалт, мониторинг хийж байна.

Энэ онд туршилт судалгааны талбайд орон нугтийн алба хаагчид, иргэдийн оролцоотойгоор төслийн баг нийт 1000 гаруй мод тарьсан. Ингэхдээ тухайн газар нутгийн онцлогт нь тохирсон улиас, хайлаас, бургас, чацаргана, нарс моддыг тарьж, ургуулж байна.

Туршилт үйл ажиллагаанд БНЧУ-ын Менделийн их сургууль тэргүүтэй Их сургуулиудын консорциум судалгааны дэмжлэг үзүүлж байна. Консорциум нь Европын Холбооны гишүүн орнуудын 8 их сургууль, АНУ-ын Ютагийн их сургууль, Монгол улсаас Монгол улсын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулиас бүрдэж байна.

## ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ (ОТМ)

Сум дундын ойн анги (СДОА), ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагын нийт 276 (123 ♀, 153 ♂) оролцогчдод ОТМ-ийн чиглэлээр доорх арга хэмжээг зургаан сэдвийн хүрээнд зохион байгуулав:

- ✓ Ойн салбарын хууль зүйн орчны тухай нэгдсэн сургалт
- ✓ Мод бэлтгэлийн ажлын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ба эрүүл ахуй
- ✓ Байгаль хамгаалагчдыг чадавхжуулах тандан судалгааны арга зүйн сургалт
- ✓ Сумын болон СДОА-ийн инженер, техникийн ажилчдын чадавхыг нэмэгдүүлэх сургалт
- ✓ Гэмтээлгүй аргаар модонд авирах сургалт
- ✓ Ойн менежментийг эрүүлээр хэрэгжүүлэх арга аргачлал



# ОЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ СУМ ДАХЬ МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР

Жавхлант суманд байгуулсан 50х30м хэмжээ бүхий навчит мод үржүүлгийн газарт үрийн болон мөчрийн тарилтын аргаар олон төрлийн мод тарьж ургуулж байна. Энэ нь 1) тарьц, суулгацын нөөцийг бий болгох, 2) орон нутгийн иргэдэд мод тарих практик сургалт зохион байгуулах зорилготой юм.

Мод үржүүлгийн газарт тус бүр 3 далан агч, хайлаас, тус бүр 1 далан шар хуайс, бүйлс, гүйлс зэрэг нийт 16,000 ширхэг модыг ургуулж байна. Үүнээс гадна мод үржүүлгийн үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг болох усалгаа, хогийн ургамлыг түүх ажлуудыг сумын ЗДТГ, иргэдийг оролцоотойгоор тогтмол хийж, үржүүлгийн талбайн хэвийн ажиллагааг хангаж байна.



Мод үржүүлгийн газар:  
2023 оны 6-р сарын 7

Мод үржүүлгийн газар:  
2023 оны 9-р сарын 13



# ОЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

## ОЙН СУДАЛГАА, БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨГӨӨН

2023 оны 6-р сарын 27-ны өдөр Их сургуулиудын консорциум болон ЗГ-ын хэрэгжүүлэгч Ойн газартай хамтран “Ойн судалгаа, бодлогын шинэчлэл” сэдэвт олон улсын зөвлөгөөнийг зохион байгуулсан. Тус зөвлөгөөн нь олон улсын хэмжээд ойн салбарын судалгааны үр дүнгийн мэдээлэл солилцох, улмаар салбарын хөгжилд түлхэц болохуйц бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Түүнээс гадна ойн хэрэглээний судалгааг хөгжүүлэхэд түлхэц өгөх зорилготой төдийгүй энэ нь эргээд ойн салбарын бодлого боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэж, Монгол улсын ойн салбарын дэвшилд хувь нэмэр оруулах юм. [Ярилцлага үзэх](#)



## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА СУДЛАХ АЯЛАЛ

Ойн аж ахуйн туршлага судлах аялалыг Менделийн их сургуультай хамтран Бүгд найрамдах Чех улсад 2023 оны 5-р сарын 21-нээс 6-р сарын 2-ны өдрүүдэд зохион байгууллаа. Аялалаар хувийн эзэмшлийн болон тусгай хэрэгцээний ойн санд зочилж мод унагах ажлаас эхлэн эцсийн бүтээгдэхүүн гаргах хүртэлх шат дамжлага бүхий үйлдвэрүүдтэй танилцаж туршлага хуримтлуулав. Түүнчлэн Чех улсын орчин үеийн мод үржүүлгийн газар болон ойтой танилцаж, суулгац бэлтгэх арга техник, ОТМ-ийн талаар тэргүүн туршлагатай танилцав. [Цааш унших](#)





# ОЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ

ХҮҮХЭД, ЗАЛУУСТ ОТМ-  
ИЙН МЭДЛЭГ ОЛГОХ  
НӨЛӨӨЛЛИЙН АРГА  
ХЭМЖЭЭ

“ОЙЧИДТОЙ НЭГ ӨДӨР”

“Ойчидтой нэг өдөр” сэдэвт танин мэдэхүйн арга хэмжээг Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал, Жавхлант сумд, Бугант тосгон, мөн Хэнтий аймгийн Биндэр, Баян-Адарга, Өмнөдэлгэр сумдад Менделийн их сургуультай хамтран зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээ нь орон нутгийн хүүхэд, залуучуудад ой модны ач холбогдлыг хөгжөөнт тоглоомоор дамжуулан ойлгуулах зорилготой байсан бөгөөд нийт 250 гаруй хүүхэд идэвхтэй оролцлоо. Хүүхдүүд тоглоомоор дамжуулан ой, түүний үүрэг, ач холбогдол зэрэг олон мэдээллийг олж авч, ойг танин мэдэх, хайрлан хамгаалах хүсэлтэй болоод зогсохгүй хамтдаа ойг цэвэрлэж, мод тарилаа. Бичлэг үзэх



БИД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДАРААХ  
ЗОРИЛГУУДАД ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ  
БАЙНА...

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН **ЗОРИЛГО**  
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХӨТЛӨХ 17 ЗОРИЛГО 2016-2030



## ХОЛБОО БАРИХ

📍 Монгол улс дахь Европын Холбооны төлөөлөгчийн газар

☎ +976 75115000

✉ [delegation-mongolia@eeas.europa.eu](mailto:delegation-mongolia@eeas.europa.eu)

📍 Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)

☎ +976 11 312282

✉ [michael.trockenbrodt@giz.de](mailto:michael.trockenbrodt@giz.de)

📍 НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO)

☎ +976 11 310248

✉ [amgalan.ariunbold@fao.org](mailto:amgalan.ariunbold@fao.org)

Дэлгэрэнгүй  
мэдээллийг  
эндээс аваарай:

